



НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 05 сарын 17 өдөр

Дугаар A/71

Улаанбаатар хот

Г Журам шинэчлэн батлах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/422 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Харьяа эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс /Г.Баянжаргал/-т тус тус даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2013 оны 12 дугаар сарын 09-ний А/143 дугаар тушаал, 2014 оны 11 дүгээр сарын 19-ний А/121 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болгосонд тооцсугай.





Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн
АЛГААР ТУШААЛЫН ХАВСРАЛТ

ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар (НЭМГ)-ын харьяа эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэр, Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгавар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон уг хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаал, албан даалгавар (цаашид “Холбогдох эрх зүйн баримт бичиг” гэх)-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэхэд мөрдөнө.

1.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-ний зорилго нь төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлж бэхжүүлэх, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийг сайжруулахад оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим

2.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээнд дараах зарчмыг баримтлана.

2.1.1. Шударга, хөндлөнгийн нөлөөнөөс хараат бус байх.

2.1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа, явц нээлттэй, тэдгээрээс гарсан тайлан, дүгнэлт нь ил тод байх.

2.1.3. Үр дүнд чиглэсэн байх.

2.1.4. Тоо баримт, судалгаа, албан ёсны мэдээлэл зэрэг нотолгоонд тулгуурласан байх.

2.1.5. Хяналт-шинжилгээг тасралтгүй, үнэлгээг тодорхой үе шаттай, тогтмол хийдэг байх.

2.1.6. Хэрэглэгч, сонирхогч талуудын оролцоог хангасан байх.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

3.1 Харьяа эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн болон тусгайлсан гэсэн 2 төрлийн ХШҮ хийнэ.

3.1.1 Гүйцэтгэлийн ХШҮ нь дараах хүрээг хамрана. Үүнд:

3.1.1.1 НЭМГ-ын дарга харьяа эрүүл мэндийн байгууллагын даргатай байгуулсан

үр дүнгийн гэрээний хэрэгжилтийн байдал

3.1.1.2 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвортой суурьшилтай ажиллуулах талаар

байгууллагын тухай жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт

3.1.1.3 Байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

3.1.1.4 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт
/журмын хоёрдугаар хавсралтад заасан чанарын үзүүлэлтуүд/

3.1.1.5 Хэрэглэгчийн үнэлгээ

3.1.1.6 Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлсэн тайлан

3.1.2 Тусгайлсан ХШҮ нь дараах хүрээг хамрана. Үүнд:

3.1.2.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт дараах бичиг баримт хамаарна:

3.1.2.1.1 Монгол Улсын хууль

3.1.2.1.2 Улсын Их хурлын тогтоол

3.1.2.1.3 Улсын Их хурлын байнгын хорооны тогтоол

3.1.2.1.4 Ерөнхийлөгчийн зарлиг

3.1.2.1.5 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр

3.1.2.1.6 Засгийн газрын тогтоол

3.1.2.1.7 Ерөнхий сайдын захирамж

3.1.2.1.8 Засгийн газрын хуралдааны тэмдэглэл

3.1.2.1.9 Засгийн газрын албан даалгавар

3.1.2.1.10 Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын болон уг хурлын
Тэргүүлэгчдийн тогтоол

3.1.2.1.11 Нийслэлийн Засаг даргын захирамж

3.1.2.1.12 Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл

3.1.2.1.13 Нийслэлийн Засаг даргын албан даалгавар

3.1.2.1.14 Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын тушаал

3.1.2.1.15 Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын албан даалгавар

3.1.2.2 Бодлогын баримт бичигт дараах баримт бичиг, үйл ажиллагаа хамаарна:

3.1.2.2.1 Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030

3.1.2.2.2 Төрөөс баримтлах бодлого

3.1.2.2.3 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр

3.1.2.2.4 Улс, Нийслэлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр,

3.1.2.2.5 Үндэсний хөтөлбөр

3.1.2.2.6 Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

3.1.2.2.7 Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт

3.1.2.2.8 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр

3.1.2.2.9 Нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

3.1.2.2.10 Шилэн дансны хөтлөлт

3.1.2.2.11 Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр

3.1.2.2.12" Нийслэлийн эрүүл мэнд" дэд хөтөлбөр

3.1.2.3 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

3.1.2.3.1 Эмчилгээ, оношлогооны стандарт, удирдамж, зааврын хэрэгжилтийн
байдал.

3.1.2.3.2 Зайлшгүй шаардлагатай болон амин чухал эмийн хангамж, эмийн
chanar, аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээ.

3.1.2.3.3 Эмчилгээ, оношилгооны шинэ арга, дэвшилтэт технологийг практикт
нэвтрүүлж, эрүүл мэндийн болон эдийн засгийн үр дүнг тооцсон байдал.

3.1.2.3.4 Эмнэлгийн тусlamж, үйлчилгээтэй холбоотой халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн.

3.1.2.3.5 Эмнэлгийн тусlamж, үйлчилгээтэй холбоотой гомдлын шийдвэрлэлт.

3.1.2.3.6 Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусlamж, үйлчилгээний талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүн.

3.1.2.4 Байгууллагын удирдлага, хөгжил

3.1.2.4.1 Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн.

3.1.2.4.2 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн.

3.1.2.4.3 Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, онцгой байдлын үеийн бэлэн байдал хангах, хариу арга хэмжээний болон нөхөн сэргээх үеийн төлөвлөгөө, хэрэгжилтийн байдал, тухайн жилд зохион байгуулсан бэлэн байдлын сургалтын тоо.

3.1.2.4.4 Байгууллагын эрсдлийн удирдлага, эрсдэл бууруулах төлөвлөгөө, хэрэгжилтийн байдал.

3.1.2.4.5 Байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран ажилласан байдал, хамтын гэрээний хэрэгжилтийн үр дүн.

3.1.2.4.6 Тухайн байгууллагаас хэрэгжүүлж байгаа судалгааны хэрэгжилт, календарчилсан төлөвлөгөөний биелэлт.

3.1.2.4.7 Байгууллагын гадаад хамтын ажиллагаа, гадаадын зээл, тусlamжаар хэрэгжүүлж буй төслийн үр дүн.

3.1.2.4.8 Байгууллагын хөгжил, соёлын талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүн.

3.1.2.5 Мэдээллийн удирдлага

3.1.2.5.1 Статистик мэдээллийн үнэн бодит, шуурхай байдал, мэдээний чанар

3.1.2.5.2 Байгууллагын цахим хуудасны тогтмолжсон байдал

3.1.2.5.3 Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд мэдээллийн технологийн зохистой хэрэглээг төлөвшүүлсэн байдал, үр дүн

3.1.2.5.4 Эрүүл мэндийн мэдээлэл, мэдээллийн технологийн талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүн

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага, зохион байгуулалт

4.1. Эрүүл мэндийн байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүргийг чанарын алба, дотоод хяналтын нэгжид хариуцуулна.

4.2. Нийслэлийн эрүүл мэндийн газар нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, хэрэгжүүлэх, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүргийг хариуцна.

4.3. Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэн хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ.

Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтны эрх, үүрэг

5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан хаагч нь дараах эрхтэй байна.

5.1.1. Байгууллагын дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны мэдээлэлтэй танилцах

5.1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамаарах мэдээлэл, баримт материалыг холбогдох нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах

5.1.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтээр зөвлөмж өгөх, өгсөн зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжлах

5.1.4. Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх

5.2. Хяналт шинжилгээ үнэлгээ хийх албан тушаалтан дараах үүрэгтэй байна.

5.2.1. Хууль тогтоомж, төрийн албаны ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах

5.2.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад олж авсан баримт, мэдээллийн нууцыг чанд хадгалж зөвхөн хяналт-шинжилгээ үнэлгээний үйл ажиллагаанд ашиглах

5.2.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах

5.2.4. Мэргэжил, мэдлэг чадвараа тогтмол дээшлүүлэн хөгжүүлэх

Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт, төрөл

6.1. Нийслэлийн эрүүл мэндийн газар нь жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг батална. Төлөвлөгөөнд зорилго, зорилт, хамрагдах байгууллага, нэгж, хэрэгжүүлэх хугацаа, зардал, хамтран оролцох байгууллага зэргийг тусгана.

6.2. Үнэлгээний зорилгоос хамааруулан үр дунд суурилсан явцын болон эцсийн үнэлгээ хийх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөнд ямар төрлийн үнэлгээ хийх талаар нарийвчлан тусгана.

6.3. Хөндлөнгийн үнэлгээг явцын болон эцсийн үнэлгээний аль ч шатанд хийж болох бөгөөд иргэд, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

6.4. Холбогдох бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх үүргийг харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга нар хариуцна.

6.5. Харьяа эрүүл мэндийн байгууллага нь тухайн жилийн үйл ажиллагааны үр дунд гүйцэтгэлийн болон тусгайлсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний тайланг энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу гарган хавсралтад заасан хугацаанд ирүүлнэ.

6.6. Нийслэлийн эрүүл мэндийн газар нь дээрх тайлангуудыг нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/422 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжид заасан хугацаанд холбогдох байгууллагад тус тус хүргүүлнэ.

6.7 Харьяа эрүүл мэндийн байгууллага нь тайлангийн төгсгөлд тайланг нэгтгэн гаргасан ажилтан, тайлантай танилцаж зөвшөөрсөн байгууллагын даргын нэр, албан тушаалаа бичиж гарын үсгээ зуран байгууллагын тамга /тэмдэг/ дарж баталгаажуулсан байх.

6.8 Шаардлага хангаагүй тайлан ирүүлсэн тохиолдолд хүлээн авахаас татгалзаж, энэ тухай байгууллагын удирдлагад мэдэгдэх бөгөөд дахин ирүүлэх хугацааг тогтоож гүйцэтгүүлнэ.

6.9 Ирүүлсэн тайлан, мэдээний чанар болон хугацаатай холбогдох хариуцлагыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.

Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

7.1. Нийслэлийн эрүүл мэндийн газар нь гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэнэ.

7.2. Тусгайлсан хяналт-шинжилгээ, үнэлгээг НЭМГ-ын холбогдох хэлтэс, алба шаардлагын дагуу гүйцэтгэнэ. Тусгайлсан хяналт-шинжилгээ үнэлгээг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран гүйцэтгэж болно.

7.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээ, хугацааг удирдамжаар тодорхойлно. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг, удирдамжийг НЭМГ-ын даргаар батлуулна.

7.4. Ажлын хэсгийн шийдвэр гаргах хэлбэр нь хурал байна. Хурлаас тэмдэглэл гарах бөгөөд уг тэмдэглэлд хуралд оролцогчид, гишүүдийн ирц, хэлэлцэх асуудлын агуулга, асуудлыг хэлэлцсэн явц болон хурлаас гарсан шийдвэрийг тус тус тусган, хуралд оролцсон гишүүдийн гарын үсгийг зурж баталгаажуулна.

7.5. Ажлын хэсгийн хурлыг нийт гишүүдийн дийлэнх олонхи оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцож, ердийн олонхийн саналаар шийдвэр гаргана.

7.6. Тайланд хяналт-шинжилгээ хийхдээ баримт бичиг судлах, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцах, санал асуулга явуулах ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

7.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгасан тоон болон тоогоор илэрхийлж болох зарим үзүүлэлтийг статистикийн болон тухайн үйл ажиллагааны хүрээний асуудлыг хариуцсан бусад байгууллагын судалгааны үзүүлэлт, тухайн жилд дээд шатны байгууллагаас газар дээр нь хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн зэрэгтэй харьцуулан нягталж үзнэ.

7.8. Жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээ нь шалгуур бурийн онооны нийлбэрийг нийт шалгуурын тоонд хувааж гаргасан дундаж оноогоор илэрхийлэгдэнэ.

7.9. НЭМГ-ын даргатай тухайн онд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ыг баримтлан дүгнэнэ.

Найм. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

8.1. Хүрэх түвшин нь тодорхойлогдсон шалгуурын гүйцэтгэлийн хувийг гаргахдаа зорилтын гүйцэтгэлийг (Γ) хүрэх түвшин буюу тавьсан зорилтод (Z) харьцуулж хувиар илэрхийлнэ. ($\Gamma/Z \times 100$). Энэхүү хувийг 0,05-аар үржүүлж ($\Gamma/Z \times 100 \times 0,05$) үнэлгээний оноог тодорхойлно.

8.2. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг дараах аргачлалаар тооцно.

8.2.1. “Үр дүнтэй” – зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь)

8.2.2. “Тодорхой үр дүнд хүрсэн” – зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь (60-89 хүртэл хувь)

8.2.3. “Эрчимжүүлэх шаардлагатай” –зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 40 хувь (31-59 хүртэл хувь)

8.2.4. “Үр дүнгүй”- зорилго, зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0 хувь (0-30 хүртэл хувь)

8.2.5. “Үнэлэх боломжгүй”-зорилго нь тодорхойгүй, шалгуур үзүүлэлт нь шаардлага хангахгүй, эсхүл шалгуур үзүүлэлттэй боловч гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй, төсөв хөрөнгө тодорхойгүй, гадаад хүчин зүйлээс шалтгаалсан зэргийг баримтаар нотолсон бол.

8.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээг дараах аргачлалаар тооцно.

8.3.1. “Бүрэн хэрэгжсэн”- холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь)

8.3.2. “Хэрэгжих шатанд”-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, хөрөнгө санхүүтэй холбоотой асуудлыг шийдвэрлэсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-89 хүртэл хувь)

8.3.3. “Хэрэгжилт хангалтгүй”- тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв хөрөнгөтэй холбоотой асуудал шийдвэрлэгдээгүй бол 30 хувь (10-49 хүртэл хувь)

8.3.4. “Хэрэгжээгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа, бэлтгэл ажил боловсруулалтын шатанд байгаа, хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь (0-9 хүртэл хувь)

8.3.5. “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”.

8.4. Бодлогын зорилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн ерөнхий дүнг гаргахдаа арга хэмжээ, зүйл, заалт бүрийн хэрэгжилтийн арифметик дунджаар тооцно. Тавьсан зорилтын арга хэмжээ, шийдвэрийн зүйл, заалтын гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулж хувиар илэрхийлнэ.

В- бодлогын зорилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн ерөнхий дүн

X-арга хэмжээ, зүйл заалтын хүрсэн түвшин

Z-арга хэмжээ, зүйл заалтын зорилтот түвшин

n-арга хэмжээ, зүйл заалтын тоо

i-үзүүлэлтийн дугаар

$$B = \frac{1}{n} \sum_{j=1}^n \left(\frac{x_i}{z_i} \right) * 100\%$$

8.5. Харьяа эрүүл мэндийн байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээний дүнг гаргахдаа үзүүлэлт бүрийн үнэлгээг 100 хүртэл хувиар илэрхийлэн нийлбэр үнэлгээний арифметик дунджийг харгалзах жинд шилжүүлнэ. Ерөнхий үнэлгээг тодорхойлоходоо жинд шилжүүлсэн дүнгүүдийн нийлбэрийг 0,05-аар үржүүлж, 0-5 хүртэл оноонд шилжүүлэн дүгнэнэ.

Е- ерөнхий үнэлгээ:

α-үр дүнгийн гэрээний хэрэгжилтийн хувь:

β-эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийн хувь:

γ-хүний нөөцийг чадавхжуулах, тогтворт суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт:

μ-байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хувь:

s-хэрэглэгчийн үнэлгээ:

с - Хяналт-шинжилгээний ажлын зөвлөмжийн хэрэгжилт

n-ур дүнгийн гэрээний арга хэмжээний тоо:

m- шалгуур үзүүлэлтийн тоо:

k- хүний нөөцийг чадавхжуулах арга хэмжээний тоо:

Ω-ил тод байдлын үзүүлэлтийн тоо:

i-үзүүлэлтийн дугаар:

$$E=0.05 * \left[\left(\frac{1}{n} \sum_{i=1}^n (\alpha_i) \right) * 0.15 + \left(\frac{1}{m} \sum_{i=1}^m (\beta_i) \right) * 0.35 + \left(\frac{1}{k} \sum_{i=1}^k (\gamma_i) \right) * 0.2 + \left(\frac{1}{\Omega} \sum_{i=1}^{\Omega} (\mu_i) \right) * 0.15 + s * 0.10 + c * 0.05 \right]$$

8.6. Ерөнхий үнэлгээний оноог үндэслэн дор дурьдсан үнэлгээний аль нэгийг өгнө. **Үнд:**

“A” буюу “Маш сайн”	90-100 хувь (4.50-5.00 оноо)
“B” буюу “Сайн”	80-89.0 хувь (4.00-4.49 оноо)
“C” буюу “Хангалттай”	70-79.0 хувь (3.50-3.99 оноо)
“D” буюу “Дутагдалтай”	60-69.0 хувь (3.00-3.49 оноо)
“F” буюу “Хангалтгүй”	0-59.0 хувь (0.00-2.99 оноо)

Ес. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

9.1. Гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан байгууллагад мөнгөн урамшуулалт олгож болно.

9.2. Тухайн жилд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр “A” буюу “Маш сайн”, “B” буюу “Сайн” үнэлгээ авсан харьяа эрүүл мэндийн байгууллагын даргыг Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу урамшуулна. Мөнгөн урамшууллын зардлыг тухайн байгууллагын төсөвт тусгасан байна.

9.3. Энэхүү журмын 9.1.-д заасан урамшуулалд шаардагдах хөрөнгийг НЭМГ-ын төсөвт тусган жил бүр батлуулна.

9.4. Харьяа эрүүл мэндийн байгууллага нь хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан зөвлөмж, дүгнэлтийн дагуу холбогдох арга хэмжээг авч, алдаа дутагдлыг засна.

9.5. Нийслэлийн эрүүл мэндийн газар нь тэргүүний арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүртээл болгоно.

9.6. Нийслэлийн эрүүл мэндийн газар нь харьяа эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар үүрэг, чиглэл өгөх, шаардлагатай тохиолдолд зохих удирдамжийн дагуу газар дээр нь хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргана.

Арав. Хариуцлага

10.1. Үнэлгээний дүнгээр “Дутагдалтай” болон “Хангалтгүй” гэж дүгнэгдсэн байгууллагын удирдлагад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

10.2. Энэхүү журмын 3 дахь бүлэгт заасныг зөрчиж худал, зөрүүтэй мэдээллээр тайлагнасан, хугацаанд тайлагнаагүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Журмын нэгдүгээр хавсралт.

**ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ХОЛБОГДОХ ЭРХЗҮЙН БАРИМТ
БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ ТАЙЛАГНАХ ХУГАЦАА**

№	Тайлангийн төрөл	Тайлан хүлээн авах хэлтэс	Тайлан ирүүлэх хугацаа /сар, өдөр/	Тайлангийн загвар
1.	Төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	12.10	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/422 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуу
2.	Засгийн газрын үйл ажиллагааны мэрийн хөтөлбөрийн биелэлт	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	05.25 12.10	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/422 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу
3.	Хууль, тогтоомж тогтоол шийдвэрийн биелэлт /МУ-ын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг ҮАБЗ-ийн зөвлөмж, ЗГ, ЭМС, НИТХ, НЗД-ын шийдвэр/	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	05.25 12.05	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/422 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу
4.	Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилт	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	08.25	-
5.	Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	05.10 12.05	МУ-ын ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын дагуу
6.	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	05.20 09.25 12.25	-
7.	“Нийслэлийн эрүүл мэнд” дэд хөтөлбөрийн биелэлт	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	12.05	-
8.	Нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжилт	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	03.20 05.20 09.01	-
9.	Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	12.05	Төрийн албаны хүний нөөцийн програм
10.	Ёсзүйн салбар хорооны тайлан/нотлох баримттай /	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ,	06.10 12.05	ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний

		ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС		ЁСЗҮЙН ХЯНАЛТЫН ХОРООНООС ИРҮУЛСЭН ХҮСНЭГТИЙН ДАГУУ
11.	Нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийн тайлан	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	12.05	Загвар 1.
12.	Хүний эрхийн тайлан	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	12.05	Хүний эрхийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд
13.	Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	12.05	НЗД-ын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/237 дугаар захирамжийн дагуу
14.	Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвортой суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийг тайлагнах хүснэгт	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	06.10 12.05	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/422 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу
15.	Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгт	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	06.10 12.05	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/422 дугаар тушаалын 8 дугаар хавсралтын дагуу
16.	Гадаад харилцааны үйл ажиллагааны тайлан /Гадаадын зээл тусlamжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр/	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	06.10 12.05	Загвар-2
17.	Байгууллагын даргын үр дүнгийн гэрээний биелэлт	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	06.10 12.10	Төрийн албаны зөвлөлийн 134 дүгээр тогтоолын дагуу
18.	Байгууллагын үйл ажиллагааны тайлан	Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	06.10 12.10	Нийслэлийн Засаг даргын 2017 оны "Журам батлах тухай" А/335 дугаар захирамжийн 9 дүгээр бүлэгт заасан бүтцийн дагуу
19.	Үндэсний хөтөлбөрүүдийн тайлан	Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс	06.10 12.05	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/422 дугаар тушаалын 6 дугаар хавсралтын дагуу
20.	Хөрөнгө оруулалтын тайлан	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	06.10 12.05	Загвар-3

ЗАГВАР-1. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

Хүснэгт 1.

.... оны ... сарын-ны өдөр

№	Байгууллага	Үзүүлэлт	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа	Урамшуулал	Нэмэгдэл			
					Мэргэжлийн зэрэг		Боловсрол, цолны	
					Их эмч	Сувилагч тусгай мэргэжилтэн	Их эмч	Сувилагч тусгай мэргэжилтэн
			Хувцас	Цаглингийн хувиар урмамшшуулах	Хоол, унааны	Зөвлөх	Профессор цолны /клиничийн профессор орохгүй/	Доктор
			Хөдөлмөрийн хэрэгсэл	Гадаадын сургалтын зардлаар урамшуулах	Тэргүүлэх	Ахлах	Магистр	Магистр
			Чийрэгжүүлэлтийн өрөө тохижуулсан	Дотоодын сургалтын зардлаар урамшуулах	Тэргүүлэх	Ахлах		
			Хамрагдсан ажилтны тоо					
			Мөнгөн дүн					

Хүснэгт 2.

.... оны ... сарын-ны өдөр

Байгууллага	Үзүүлэлт	Сургалтын зардал		Дотоод журмын дагуу										Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйл			
		Гадаадын сургалтын	Дотоодын сургалтын	Ахмадын баяр	Хүүхдийн баяр	Түлээх нүүрсний хөнгөлөлт	Цалинтай чөлөө	Цалингүй чөлөө	Хэвтэн эмчлүүлэх орхоногийн хөнгөлөлт	Тэтгэвэрт байгаа туслаамж олгох	Орон нутагт ирж очсон унааны зардал	ТАХ-ын хүүхдийн сургалтын зардал	29.5	29.6	29.7	29.8	
	Хамрагдсан ажилтны тоо Мөнгөн дүн	Газар олгуулсан Гар утас олгосон Гэр олгосон Ахмадын баяр Хүүхдийн баяр Түлээх нүүрсний хөнгөлөлт Цалинтай чөлөө Цалингүй чөлөө Хэвтэн эмчлүүлэх орхоногийн хөнгөлөлт Тэтгэвэрт байгаа туслаамж олгох	Гадаадын сургалтын Дотоодын сургалтын Байгууллагын Газар олгуулсан Гар утас олгосон Гэр олгосон Ахмадын баяр Хүүхдийн баяр Түлээх нүүрсний хөнгөлөлт Цалинтай чөлөө Цалингүй чөлөө Хэвтэн эмчлүүлэх орхоногийн хөнгөлөлт Тэтгэвэрт байгаа туслаамж олгох	Гарч ахмадад гарч ахмадад	Орон нутагт ирж очсон унааны зардал												

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

АЛБАН ТУШААЛ

гарын үсэг

НЭР

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:

БАЙГУУЛЛАГЫН ДАРГА

гарын үсэг,
тамга /тэмдэг/

НЭР

ЗАГВАР-2. ГАДААД ХАРИЛЦААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Хүснэгт 1. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа тесэл, арга хэмжээний гүйцэтгэлийн тайлан

20... оны сарын өдөр

20... Оны Сарын өдөр																			
№	Төсөл, хөтөлбөрийн нэр	Оролцогч талууд		Төслийн тодорхойл олт болон зорилго	Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдох шийдвэр, эрх зүйн актууд				Хийгдсэн томоохон ажлууд	Цаашид төвлөвлөж буй ажлууд	Тухайн жилийн гүйцэтгэл хувиар	Төслийн нийт гүйцэтгэл хувиар	Шийдвэрлэх шаардлагатай асуудлууд	Байршил		Хэмжих нааж	Хүчин чадал	Хэрэгжүүлэх хугацаа	
		Санхүү жүүлэгч байгуулага	Хэрэгжүүлэгч байгууллага		ҮИХ-ын тогтоол /огноо, дугаар/	ЗГ-ын тогтоол /огноо, дугаар/	НИТХ-ын тогтоол /огноо, дугаар/	Захирамж, тушаал, санамж бичиг, гэрээ /огноо, дугаар/						Дүүрэг	Хороо			Эхэлж	Дусах
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20

Хэрэгжиж буй төслийн хамаарах салбарыг сонгож бичих: 1.Хот байгуулалт, дэд бутэц 2.Байгаль орчин, ногоон хөгжлийн

Санхүүжилтийн хэлбэр	Нийт төсөвт өртөг (мян ам,доллар)	Санхүүжилт /гүйцэтгэлээр мяняам			Санхүүжилт			Холбогдох баримт бичиг байгаа эсэх				Төслийн талаарх нэмэлт тайлбар	Мэдээлэл ирүүлсэн байгууллага	Тухайн төслийг хариуцсан мэргэжилтэн /албан тушаал, холбогдох утас/	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн талаарх мэдээлэл /бүтэц, орон тоо, холбогдох мэдээлэл/
		Өмнөх жилүүдийн санхүүжилт	2017 он /өссөн дүнгээр/	2018 он /өссөн дүнгээр/	2019 он	2020 он	2021 он	ТЭЗҮ	Батлагдсан зураг, төсөв	Газрын зөвшөөрөл	Техникийн нөхцөл				
21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36

3. Нийгмийн хөгжил 4. Засаглал, төрийн үйлчилгээ 5. Үйлдвэржилт, хөдөө аж ахуй

Хүснэгт 2. Гадаадын өндөр хөгжилтэй оронд сургалтад хамрагдсан байдал

20... оны сарын өдөр

№	Овог	Нэр	Регистрийн дугаар	Албан тушаал	Суралцсан чиглэл	Суралцсан хугацаа	Суралцсан улс байгууллага	Сургалтын зардлын хэлбэр /улсын, байгууллагын хувийн/
1								
2								
3								
4								
5								

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

АЛБАН ТУШААЛ

гарын үсэг

НЭР

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:

БАЙГУУЛЛАГЫН ДАРГА

гарын үсэг,
тамга /тэмдэг/

НЭР

ЗАГВАР 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЙЛАН

Хүснэгт 1. Барилга, байгууламж засварууд

20... оны .. дугаар сарын ...-ны өдөр

№	Төсөл, арга, хэмжээний нэр	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр /төгрөг /				Гүйцэтгэгч байгууллага	Ашиглалтанд хүлээн авсан огноо	Тайлбар /чанар, ашиглалтын байдал/
		Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Төсөл, хөтөлбөр /нэр тодорхой бичих/	Хандив, тусламж			
1.	Шинэ барилга							
2.	Их засвар							
3.	Үргсгал засвар							
	Нийт							

Хүснэгт 2. Тоног төхөөрөмжүүд

№	Тоног төхөөрөмжийн төрөл	Тоног төхөөрөмжийн нэр Марк, загвар	Үйлдвэрлэсэн улс Үйлдвэрлэсэн огноо	Too, хэмжээ Нэгжүнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг / Улсын төсөв	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр Орон нутгийн төсөв	Төсөл, хөтөлбөр /нэр тодорхой бичих/ Хандив тусламж	Гүйцэтгэч /нийлүүлэгч/ байгууллага	Ашиглалтанд авсан огноо	Хүлээн Тайлбар /чанарын ашиглалтын байдал/
---	--------------------------	--	--	---------------------------------	-----------------------------------	--	--	------------------------------------	-------------------------	--

1.	Эмнэлгийн тоног төхөөрөмж							
1.1	Дотор мэдрэлийн чиглэлийн							
1.2	Мэс заслын чиглэлийн							
1.3	Сэхээ амьдруулах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний							
1.4	Эх барих эмэгтэйчүүдийн							
1.5	Лабораторийн							
1.6	Дуран оношлогоо							
1.7	Рентген оношлогоо							
1.8	Хэт авиан оношлогоо							
1.9	Хүүхэд							
1.10	Шүд эрүү нүүр							
1.11	Нүд							
1.12	Чих хамар хоолойн							
1.13	Гэмтэл нөхөн сэргээх эмчилгээний							
1.14	Физик эмчилгээ /уламжлалтын /							
1.15	Бусад							
	Нийт							
	Хөрөнгө оруулалтын нийлбэр дүн.							

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

АЛБАН ТУШААЛ

гарын үсэг

НЭР

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:

БАЙГУУЛЛАГЫН ДАРГА

гарын үсэг,
тамга /тэмдэг/

НЭР

Журмын хоёрдугаар хавсралт.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

НЭГ. Эрүүл мэндийн төвийн шалгуур үзүүлэлт

Хүснэгт 1.

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Тайлбар
1	Эхийн эндэгдэл /100000 амьд төрөлтөд/			
2	0-1 насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/			
3	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/			
4	Хоног болоогүй нас баралтын хувь			
5	8-24 цагийн доторхи нас баралтын хувь			
6	Үндсэн оношийн зөрүүний хувь			
7	28-36 долоо хоногтой төрсөн дутуу нярайг амьдруулсан хувь*			
8	Төрсний дараах эхний 1 минутад аргарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь*			
9	Төрсний дараах эхний 5 минутад аргарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь*			
10	Амьгүй төрөлтийн түвшин, 1000 төрөлтөд			
11	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин			
12	Үр хөндөлтийн түвшин			
13	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох үр хөндөлтийн түвшин			
14	Гэрийн төрөлтийн хувь			
15	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь			
16	Өрхийн эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт гэрийн эргэлтийн эзлэх хувь			
17	Жирэмсний эхний 3 сард хяналтанд орсон эхийн эзлэх хувь			
18	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь			
19	Чихрийн шижин хэв шинж -2 өвчний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь			
20	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь			
21	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь			
22	Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтын хувь			

		Дархлаажуулалтын хамралтыг 95%-д хүргэсэн хорооны хувь			
		Товлолын дархлаажуулалтын бүрэн тунгийн хамралт			
23	Товлолт дархлаажуулалтын хамралтын хувь	Товлолын дархлаажуулалтын тун хоорондын завсардалтын хувь: Тавт1-Тавт3, Тавт3-УГУ1, УГУ1-ВГА1, ВГА1-ВГА2			
24	Тархвар судлалын заалтаар дархлаажуулсан хувь	Хепатит В вирусын халдвартын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хувь Эрсдэлт бүлгийн хүн амыг томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулсан хувь			
25	Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн хувь				
26	ӨЭМТ-ийн дархлаажуулалтын нэгжийн эзлэх хувь				
27	Нийт төрөлтөөс кесар хагалгаагаар шийдвэрлэсэн төрөлтийн хувь*				
28	Үүнээс өсвөр насны эмэгтэйн төрөлтөөс кесар хагалгаагаар шийдвэрлэсэн төрөлтийн хувь*				
29	Нийт мэс засалд давтан хагалгааны эзлэх хувь				
30	Мэс заслын дараах хүндрэлийн эзлэх хувь				
31	Вирус гепатит өвчлөл /10,000 хүн амд/				
32	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин /10 000 хүн амд/				
33	Эмчилгээнд орсон халдвартай хэлбэрийн сүрьеэгийн өвчтөнөөс эмчилгээний төгсгөлд эдгэрсэн хувь				
34	Зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдвартын түвшин /10 000 хүн амд/				
35	Өсвөр насны 1000 хүнд ногдох БЗДХ-ын түвшин				
36	Төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын тоо				
37	Идэвхтэй илрүүлэлтээр илэрсэн БЗДХ-ын тохиолдлын тоо Үүнээс эмчилгээнд хамрагдсан хүний тоо	Нийт өвчлөл Үүнээс Идэвхтэй илрүүлэлтээр илэрсэн БЗДХ-ын тохиолдлын тоо Үүнээс эмчилгээнд хамрагдсан хүний тоо			
38	Эмнэлгээс шалтгаалах халдвартын тоо				
39	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь				

* Төрөлт бүхий ЭМТ-үүдээд

ХОЁР. Нэгдсэн эмнэлгийн шалгуур үзүүлэлт

Хүснэгт 2.

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Тайлбар
1	Эмнэлгийн нас баралтын хувь			
2	Хоног болоогүй нас баралтын хувь			
3	8-24 цагийн доторх нас баралтын хувь			
4	Үндсэн оношийн зөрүүний хувь			
5	0-1 насны эндэгдэл /тухайн насны эмнэлэгт хэвтэж эмчлэгдсэн хүүхдийн тоонд харьцуулсан хувь/			
6	1-5 насны эндэгдэл /тухайн насны эмнэлэгт хэвтэж эмчлэгдсэн хүүхдийн тоонд харьцуулсан хувь/			
7	Эмнэлгээс шалтгаалах халдвартын тоо			
8	Мэс заслын дараах хүндрэлийн хувь			
9	Мэс заслын давтан хагалгааны хувь			
10	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь			
11	Хепатит В вирусын халдвартын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хувь			

ГУРАВ. Амаржих газрын шалгуур үзүүлэлт

Хүснэгт 3.

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Тайлбар
1	Эмнэлгийн нас баралтын хувь			
2	Хоног болоогүй нас баралтын хувь			
3	8-24 цагийн доторх нас баралтын хувь			
4	Үндсэн оношийн зөрүүний хувь			
5	Товтолт дархлаажуулалтын хамралтын хувь /товтолын ангиллаар/	Сүрьеэ Хепатит В вирусын эсрэг Үүнээс: Хепатит В вирусын эсрэг дархлаажуулалтад 24 цагийн дотор хамрагдсан нярай хүүхдийн эзлэх хувь Халдварт саа		
6	Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалтын мэдээ ирүүлэлтийн хувь			
7	Нийт төрөлтөөс кесар хагалгаагаар шийдвэрлэсэн төрөлтийн хувь			
8	Үүнээс өсвөр насны эмэгтэйн төрөлтөөс кесар хагалгаагаар шийдвэрлэсэн төрөлтийн хувь			
9	Кесаров хагалгааны дараах давтан мэс заслын хувь			
10	28-36 долоо хоногтой төрсөн дутуу нярайг амьдруулсан хувь			
11	Төрсний дараах эхний 1 минутад апгарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь			
12	Төрсний дараах эхний 5 минутад апгарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь			
13	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)			
14	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)			

15	Амьгүй төрөлтийн түвшин, 1000 төрөлтөд			
16	Үр хөндөлтийн түвшин			
17	Үр хөндөлтийн дараах хүндрэлийн хувь			
18	Эмнэлгээс шалтгаалах халдвартын тоо			
19	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь			

ДӨРӨВ. Тосгоны эрүүл мэндийн төвийн шалгуур үзүүлэлт

Хүснэгт 4.

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Тайлбар
1	Эмнэлгийн нас баралтын хувь			
2	8-24 цагийн доторхи нас баралтын хувь			
3	Хоног болоогүй нас баралтын хувь			
4	Эмнэлгийн дотоод халдвартын тохиолдлын тоо			
5	0-1 насны хүүхдийн эндэгдэл /тухайн насны эмнэлэгт хэвтэж эмчлэгдсэн хүүхдийн тоонд харьцуулсан хувь/			
6	1-5 насны хүүхдийн эндэгдэл /тухайн насны эмнэлэгт хэвтэж эмчлэгдсэн хүүхдийн тоонд харьцуулсан хувь/			
7	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь			
8	Тосгоны эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт гэрийн эргэлтийн эзлэх хувь			
9	Жирэмсний эрт хяналтын хувь			
10	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь			
11	Чихрийн шижин хэв шинж -2 өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь			
12	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь			
13	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгэнд хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь			
14	Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтын хувь			
15	Нийт дуудлагаас 20 минутын очилт			
16	Нийт дуудлагад 20 минутаас дээшхи дуудлагын хүлээгдлийн эзлэх хувь			
17	Вируст хепатитын өвчлөлийн түвшин (10 000 хүн амд)			
18	Идэвхтэй илрүүлэлтээр илэрсэн БЗДХ-ын тохиолдлын тоо Үүнээс эмчилгээнд хамрагдсан хүний тоо			

19	Товлолт дархлаажуулалтын хамралтын хувь /товлолын ангиллаар/ /Гачуурт тосгоны ЭМТ-өөс бусдад хамааралтай/			
20	Хепатит В вирусын халдвартын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хувь			
21	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь			

ТАВ. Наркологийн эмнэлгийн шалгуур үзүүлэлт

Хүснэгт 5.

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Тайлбар
1	Эмнэлгийн нас баралтын хувь			
2	Хоног болоогүй нас баралтын хувь			
3	8-24 цаг доторх нас баралтын хувь			
4	Үндсэн оношийн зэрүүний хувь			
5	Эмнэлгийн дотоод халдвартын тохиолдлын тоо			
6	Давтан эмчлэгдсэн өвчтний тоо			
7	Хепатит В вирусын халдвартын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хувь			
8	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь			

ЗУРГАА. Энэрэл эмнэлгийн шалгуур үзүүлэлт

Хүснэгт 6.

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Тайлбар
1	Эмнэлгийн нас баралтын хувь			
2	Хоног болоогүй нас баралтын хувь			
3	8-24 цаг доторх нас баралтын хувь			
4	Үндсэн оношийн зөрүүний хувь			
5	Эмнэлгийн дотоод халдвартын тохиолдлын тоо			
6	Хэвтэн эмчлүүлсэн эмзэг бүлгийн иргэдийн тоо, хувь			
7	Сүрьеэ өвчний улмаас хяналтад байгаа хүний тоо			
8	Сүрьеэгийн эдгэрэлтийн хувь			
9	Сүрьеэгийн эмчилгээний амжилт			
10	Хепатит В вирусын халдвартын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хувь			
11	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь			

ДОЛОО. Шүд эрүү нүүрний төвийн шалгуур үзүүлэлт

Хүснэгт 7.

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Тайлбар
1	Шүд цоорох өвчний илрүүлэлтийн хувь			
2	Эмнэлгээс шалтгаалах халдварын тоо			
3	Мэс ажилбарын дараах хүндрэлийн хувь			
4	Эмчилгээний дараах хүндрэлийн хувь	.		
5	Эрүүлжилтийн хувь			
6	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь			
7	Хепатит В вирусын халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хувь			

НАЙМ. Нийслэлийн түргэн тусlamжийн төвийн шалгуур үзүүлэлт

Хүснэгт 8.

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Тайлбар
1	Яаралтай дуудлагаас 20 минутын очилт			
2	Нийт дуудлагад эмнэлэг хүртэлх тусlamж үйлчилгээний үзүүлэлтийн хувь			
3	Яаралтай бус дуудлагын 20 минутаас дээшхи дуудлагын хүлээгдлийн эзлэх хувь			
4	Автомашины техникийн бэлэн байдлын хувь			
5	Хепатит В вирусын халдвартын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хувь			

ЕС.Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн шалгуур үзүүлэлт

Хүснэгт 9.

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Тайлбар
1	Идэвхтэй тандалтаар шинээр илрүүлсэн голомтын тоо			
2	Тухайн жилд төлөвлөгдсөн тандалтын гүйцэтгэлийн хувь			
3	Хүн амын дундах зоонозын өвчний халдварталтын хувь			
4	Зоонозын халдварт өвчний өвчлөл (10 000 хүн амд)			
5	Лабораторийн оношийг баталгаажуулсан хувь			
6	Эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулалтад хамруулсан хувь (нэр төрлөөр)			
7	Байгууллага, аж ахуй нэгж, ажилтнуудад мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгсөн байдал (давтамж, тоо)			
8	Зоонозын халдварт өвчний дуудлагад цаг хугацаандаа үйлчилсэн тоо			
9	Зоонозын халдвартын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлыг лабораторийн шинжилгээнд хамруулсан хувь			
10	Хепатит В вирусын халдвартын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хувь			